

ДОТОР ЦАХИЛГААН, ХОЛБОО ДОХИОЛОЛ, ГАЛЫН АВТОМАТИКИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

..... оны ... дугаар
сарын ... -ны өдөр

№

Улаанбаатар хот

Энэхүү ГЭРЭЭГ дор дурдсан ТАЛУУД харилцан тохиролцож байгуулав.

Нэг талаас: тоотод байрлах “.....” ХХК (цаашид "Захиалагч" гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал

Нөгөө талаас: тоотод байрлах “.....” ХХК (цаашид “Гүйцэтгэгч” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал нар,

Монгол Улсын Иргэний хуулийн 189 дүгээр зүйл болон 343-358 дугаар зүйлийг удирдлага болгон дараах гэрээг харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү гэрээний дагуу Гүйцэтгэгч нь барилгын дотор цахилгаан, холбоо дохиолол, галын автоматикийн ажлыг холбогдох зураг төслийн дагуу гүйцэтгэн, шаардлагатай бүхий л зөвшөөрлийг холбогдох байгууллагаас авах зэрэг ажлыг хууль тогтоомж, дүрэм, журам, норм стандартад заасан нөхцөлийн дагуу хийж гүйцэтгэх бөгөөд Захиалагч нь энэхүү гэрээгээр тохиролцсон хөлсийг төлнө.
- 1.2. Гүйцэтгэгч нь энэ гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд энэ гэрээний хугацаанд тэрхүү тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байдлыг хангах үүрэгтэй. Энэ шаардлагыг хангаагүйгээс үүсэх аливаа эрсдэл, зардлыг Гүйцэтгэгч хариуцна.
- 1.3. Гэрээт ажил (цаашид “Гэрээт ажил” гэх)-д дараах ажлыг хамруулж ойлгоно. Үүнд:
 - 1.3.1. Дотор цахилгаан хангамжийн ажил
 - 1.3.2. Дотор холбоо, дохиоллын ажил
 - 1.3.3. Галын автоматикийн ажил
 - 1.3.4. Энэ гэрээний зорилгыг хангахад шаардагдах бусад ажил үүрэг.
- 1.4 Дараах баримт бичиг энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
 - 1.4.1 Гэрээт ажлын төлбөр, төлбөр төлөх нөхцөл /Хавсралт №1/
 - 1.4.2 Ажил гүйцэтгэх график /Хавсралт №2/

ХОЁР. ХУГАЦАА

- 2.1. Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж ажлыг эцсийн байдлаар хүлээн авсан актад Захиалагч гарын үсэг зурж, Гүйцэтгэгчийн ажлын үлдэгдэл хөлсийг төлснөөр дуусгавар болно.
- 2.2. Ажил гүйцэтгэх хугацааг ажлын графикаар тодорхойлно.
- 2.3. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн графикаар ажил явуулж, энэхүү гэрээний 7 дахь заалтад заасан нөхцөл байдлын улмаас ажил зогсох, эрчим хүчний доголдол үүсэхээс бусад тохиолдлоор 2.2-д заасан хугацаанд ажлыг бүрэн хийж дуусган захиалагчид хүлээлгэн өгнө.

- 2.4. Талууд харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгаж болно. Энэ тохиолдолд гэрээг сунгах хүсэлтэй тал гэрээг сунгах тухай бичгэн мэдэгдлийг энэ гэрээний хугацаа дуусгавар болохоос 1 /нэг/ хоногийн өмнө нөгөө талдаа хүргүүлнэ.
- 2.5. Гэрээг сунгах тухай мэдэгдэл хүлээн авсан тал мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 1 өдөрт багтаан хариу ирүүлнэ.
- 2.6. Энэхүү гэрээний 2.4 дэх хэсэгт заасан хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд хүлээн зөвшөөрөөгүйд тооцно.
- 2.7. Хэрвээ талууд гэрээний хугацааг сунгахаар харилцан тохиролцсон бол бичгээр нэмэлт гэрээ хийж, гарын үсэг зурсан байна.
- 2.8. Ийнхүү хугацаа сунгагдсан нь гэрээний үнэ нэмэгдэх шалтгаан болохгүй.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Гүйцэтгэгч нь дараах үүрэгтэй. Үүнд:

- 3.1.1. Гэрээний дагуу Гэрээт ажлыг батлагдсан зураг төсөл, зохих журам, стандартын дагуу мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж Захиалагчид гэрээнд заасан хугацаанд нь хүлээлгэж өгөх;
- 3.1.2. Гүйцэтгэгч нь энэ гэрээнд заасан Гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай бараа, материал, тоног төхөөрөмж, тоноглолыг бүрэн хариуцна.
- 3.1.3. Шаардлагатай тохиолдолд ажил гүйцэтгэхэд шаардлагатай зөвшөөрлийг төрийн холбогдох эрх бүхий байгууллагаас авч ажлыг гүйцэтгэнэ.
- 3.1.4. Захиалагчийн баталсан барилгын талбайн зохион байгуулалт, журмын дагуу ажиллаж, ажил гүйцэтгэх бараа материалыг заасан газар, цэгт байрлуулан, ХАБЭА-ын нөхцөл, шаардлагыг ханган ажиллах, өөрийн эд хөрөнгийг хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хариуцах;
- 3.1.5. Гэрээнд заасан ажлыг гүйцэтгэх явцдаа хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой аливаа хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөх,
- 3.1.6. Ажил гүйцэтгэхтэй холбогдуулан олж авсан, мэдсэн Захиалагчид холбогдолтой аливаа мэдээлэл, баримт материал, зураглал, тооцооллын нууцлалыг чанд хадгалах,
- 3.1.7. Гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй бөгөөд өөрөө зөвшөөрсөн тохиолдолд туслан гүйцэтгэгч авч ажиллуулж болох ба туслан гүйцэтгэгчийн үйлдэл, гүйцэтгэлийг Захиалагчийн өмнө бүрэн хариуцах;
- 3.1.8. Гэрээт ажлыг гүйцэтгэх явцад Гүйцэтгэгчийн үүргийн биелэлт болон ажлын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх, эсхүл урьдчилж харах боломжгүй ямарваа нэгэн нөхцөл байдал илэрвэл энэ талаар Захиалагчид нэн даруй мэдэгдэж, цаашид хэрхэх, эрсдэлээс зайлсхийх талаар харилцан санал солилцож шийдвэрлэх;
- 3.1.9. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээр үүссэн тодорхойгүй байдлыг Захиалагчтай зөвшилцсөн шийдвэрлэх;
- 3.1.10. Гүйцэтгэгч нь өөрийн хийж гүйцэтгэсэн бүхий л ажилд шаардагдах шугам, тоноглолын угсралт, суурилуулалт, хэмжилт туршилт, тохируулгыг бүрэн хариуцна.

3.2. Гүйцэтгэгч нь дараах эрхтэй. Үүнд:

- 3.2.1. Гэрээний Хавсралт №1-т заасан журмаар, гүйцэтгэсэн ажлын үр дүнд

тохирсон төлбөрийг Захиалагчаас шаардан авах;

3.2.2. Захиалагчаар ажил гүйцэтгэх шаардлагатай талбай, орчноор хангуулах;

3.2.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Захиалагчаас шаардах эрхтэй.

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Захиалагч нь дараах үүрэгтэй. Үүнд:

4.1.1. Захиалгат ажлын хөлсийг Гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлтэй уялдуулан гэрээний Хавсралт №1-ийн хүснэгт 2 (Санхүүжилтийн график)-г заасан журмаар төлөх;

4.1.2. Захиалагч тал гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ажил гүйцэтгэх боломжоор хангах,

4.1.3. Хэрэв гэрээнд заасан ажлын үр дүнг зориулалтын дагуу ашиглахад эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авах шаардлагатай бол зөвшөөрөл авахтай холбоотой бичиг баримтыг бүрдүүлэхэд гүйцэтгэгчид дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

4.1.4. Шинээр гүйцэтгэх ажлын хийц, төлөвлөлт, материалын талаар Гүйцэтгэгчтэй зөвшилцөн сонгох;

4.2. Захиалагч нь дараах эрхтэй. Үүнд:

4.2.1. Захиалагч тал гэрээнд заасан нөхцөл, чанар стандартын дагуу гэрээний зүйлийг гүйцэтгэх, хүлээлгэн өгөхийг Гүйцэтгэгчээс шаардах;

4.2.2. Ажлын гүйцэтгэлийг тухай бүр хянах, ажлын явцтай танилцах, ажлын явцын талаар мэдээлэл авах, өөрийн саналаа оруулах, ажил дууссаны дараа ажлын акт гүйцэтгэлээр хүлээн авах бөгөөд захиалгыг зөрчиж буруу, дутуу, чанар стандарт, техникийн шаардлага хангаагүй ажлыг тогтоосон хугацаанд засах, гүйцээн хийхийг шаардах, уг шаардлагыг биелүүлэх хүртэл санхүүжилтийг зогсоох эрх эдэлнэ.

4.2.3. Гүйцэтгэгчээс ХАБЭА-ын нөхцөлийг хангах, өөрийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг ханган ажиллахыг шаардах;

ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

5.1. Энэ гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тал нь тэрхүү буруутай үйлдлийн улмаас нөгөө талдаа учирсан хохирол, зардлыг (гэрээний үнийн дүн, алданги, торгууль төлснийг үл харгалзан) хариуцна.

5.2. Ажлын гүйцэтгэлийн болон гэрээ дүгнэх үед Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажилд ямар нэг доголдол илэрвэл Гүйцэтгэгч доголдлыг өөрийн зардлаар арилгах үүрэг хүлээнэ.

5.3. Доголдол гэдэгт Гүйцэтгэгч ажлыг батлагдсан заавар, зохих журам, стандартын дагуу мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгээгүйг ойлгоно.

5.4. Талууд гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд буруутай тал нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувийн алдангийг хоног тутам төлнө.

5.5. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байх үед аль нэг тал гэрээнээс сайн дураар татгалзвал, эсхүл Гүйцэтгэгч ажлыг зогсоовол гэрээний үнийг дүнгийн 20 хувьтай тэнцэх торгуулийг гэрээнээс татгалзсантай холбоотойгоор нөгөө талдаа учруулсан хохирол, зардлын хамт төлөх үүрэгтэй.

5.6. Гүйцэтгэгч нь ажлын гүйцэтгэлийн чанар, аюулгүй байдал, доголдолгүй байдлыг

Захиалагч болон гуравдагч этгээдийн өмнө бүрэн хариуцах бөгөөд учирсан хохирлыг дангаараа барагдуулна.

ЗУРГАА. АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ

- 6.1. Гүйцэтгэгч нь ажлыг бүрэн гүйцэтгэн Захиалагчийн төлөөлөгчид ажлын үр дүнг шалгуулан хүлээлгэн өгсөн тухай акт үйлдэнэ.
- 6.2. Гүйцэтгэгч ажлыг Захиалагчид хүлээлгэн өгөхөөс өмнө **улсын комисс ажиллуулан**, хүлээлгэн өгсөн байна.
- 6.3. Ажил хүлээлгэн өгсөн актад гүйцэтгэсэн ажлын жагсаалт, холбогдох төлбөрийн дэлгэрэнгүй, ажлын шалгасан үр дүнг тусгана.

ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 7.1. Гэрээний аль нэг тал гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл / тухайлбал : газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт, цар тахал болон байгалийн бусад аюулт үзэгдэл, бослого, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно
- 7.2. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 7.3. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

НАЙМ. ГЭРЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БА ЦУЦЛАХ

- 8.1. Гэрээний аль нэг тал гэрээний үүргээ зөрчсөн бол нөгөө тал нь энэ талаар мэдсэн даруй зөрчлийг арилгах талаар бичгээр шаардлага тавина. Хүргүүлсэн шаардлагыг хүлээн авсан тал 7 хоногийн дотор арилгаагүй бол зөрчил гаргаагүй тал гэрээг цуцлах мэдэгдлийг дахин хүргүүлэх ба ингэснээр гэрээ цуцлагдсанд тооцно.
- 8.2. Гэрээ цуцлагдахад хүргэсэн гэм буруутай үйлдэл гаргасан тал ийнхүү гэрээ цуцалснаас нөгөө талд учирсан хохирлыг бүрэн хариуцна.
- 8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэн талуудын эрх бүхий ажилтан гарын үсэг зурж баталгаажуулснаар гэрээнд хавсаргана. Нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд гэрээний нэгэн адил хүчинтэй байна.

ЕС. БУСАД ЗҮЙЛ

- 9.1. Энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хэлэлцээрийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Маргааныг хэлэлцээрийн журмаар шийдвэрлэх боломжгүй болсон тохиолдолд Монголын Барилгын Үндэсний Ассоциацийн дэргэдэх Барилга, Дэд бүтцийн Олон Улсын Арбитраар түүний хэрэг хянан шийдвэрлэх дүрмээр шийдвэрлүүлнэ.
- 9.2. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний дагуу хийж гүйцэтгэхээр харилцан тохиролцсон бүхий л ажлыг стандартын дагуу чанарын өндөр төвшинд хийж гүйцэтгэх туршлага,

ур чадвартай бөгөөд ажлыг хугацаанд гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн боловсон хүчинтэй болохоо үүгээр баталж байна.

- 9.3. Талууд захиалгат ажлын үр дүнг хүлээлцэхдээ комисс томилон акт үйлдэх ба улсын комиссын актыг үндэслэнэ. Актыг баталгаажуулж гэрээнд хавсаргах бөгөөд энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 9.4. Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагчийг төлөөлж:

.....

Гүйцэтгэгчийг төлөөлж:

.....

ГЭРЭЭТ АЖЛЫН ТӨЛБӨР, ТӨЛБӨР ТӨЛӨХ НӨХЦӨЛ

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГРАФИК